



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 30 өдөр

Дугаар А/94

Хужирт сум

Дуудлага худалдаа явуулах ажлын  
хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Засгийн газрын 2016 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн 10 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам"-ын 9 дүгээр зүйлийн 9.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Газар эзэмших эрхийн гэрчилгээний дуудлага худалдааг 2023 оны 06 дугаар сарын 05-ны өдөр зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Л.Цэдэв (Хууль, эрх зүй хариуцсан мэргэжилтэн)  
Дуудлага худалдааны хөтлөгч: Ц.Нямдорж (Газрын даамал)  
Тэмдэглэл хөтлөгч: Д.Мөнхбат (Бэлчээр, газар тариалангийн асуудал хариуцсан мэргэжилтэн)

2. Ажлын хэсгийн ахлагч (Л.Цэдэв)-д ДААЛГАХ нь:

а. Газар эзэмших эрхийн гэрчилгээний дуудлага худалдааны анхны үнийг Барилга, хот байгуулалтын сайдын 2018 оны 12 сарын 14-ний өдрийн 208 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан "Газар эзэмших, ашиглах эрхийн дуудлага худалдааны анхны үнийг тодорхойлох аргачлал"-ын дагуу тогтоож, зохих журмын дагуу Газрын цахим биржийн [www.mle.mn](http://www.mle.mn) хаягаар дуудлага худалдааг зохион байгуулах;

б. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 15.1 дэх заалтыг хэрэгжүүлж ажиллах;

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ

622201187  
D:My doc; Zahiramj 2023